



ХӨГЖИЛД
ХАМТДАА

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
2024 он**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

ҮНДСЭН 9 ЗАРЧИМ:

- 1 **Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт**
“Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.”
- 2 **Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг**
“Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаагаа тодорхой чиг хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ.”
- 3 **Тайлагнал, мэдээллийн ил тод байдал**
“Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.”
- 4 **Аудит, хяналтын тогтолцоо**
“Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.”
- 5 **Эрсдэлийн удирдлага**
“Компани эрсдэлийн удирдлагын тогтолцоог зүй зохистой, хараат бус байдлаар зохион байгуулж, уг тогтолцооны үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.”
- 6 **Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал**
“Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.”
- 7 **Оролцогч талуудын эрх ашиг**
“Компани нь үйл ажиллагаа явуулахдаа бусад оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэнэ.”
- 8 **Компанийн соёл**
“Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанидаа бизнесийн ёс зүй, хариуцлагын өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтанд мөрдлөг болгон хэвшүүлнэ.”
- 9 **Хувьцаа эзэмшигчдийн эрх**
“Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, холбогдох мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.”

Үнэлгээний бүтэц

Компанийн засаглалын кодекс нь үндсэн 9 зарчмыг баримтлан 36 асуулга бүхий асуулгын дагуу дараах аргачлалаар үнэлдэг байна.

Үнэлгээний аргачлал

Асуулга тус бүрийн хувьд хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж, хувьд шилжүүлэн үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно. Үүнд:

- ✓ Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- ✓ Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- ✓ Үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн:

- ✓ Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- ✓ 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- ✓ 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- ✓ 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙНХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Санхүүгийн зохицуулах хорооноос Хөрөнгийн биржид бүртгэлтэй 111 хувьцаат компанийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн, үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг 2024 оны байдлаар тооцон тайлангийн үнэлгээг хянан баталгаажуулахад кодексийн хэрэгжилтийн дундаж үнэлгээгээр “Худалдаа, хөгжлийн банк” ХК нь 91.7 хувиар 20 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	ХХБ-ны авсан оноо
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6
5	Эрсдэлийн удирдлага	8	8
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7
8	Компанийн соёл	6	6
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10
Нэгдсэн дүн		72	66
Үнэлгээний хувь		91.7%	

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

		Үнэлгээ	Тайлбар
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	2	Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “ХХБ” эсхүл “Банк” гэх)-ийн дүрмээр Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь нийт 9 гишүүнтэй, үүний 1/3 хараат бус гишүүд байхаар Компанийн тухай хууль, Банкны тухай хуулийг мөрдлөг болгон баталсан нь сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, ТУЗ-ийн шийдвэр гаргалтад хараат бус гишүүдийг оролцоо, бие даасан байдлыг хангахад гол чиглүүлэгч болдог. ТУЗ гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмыг 2022 онд анхлан баталж байсан бөгөөд холбогдох хууль, журам, шаардлагад нийцүүлэн 2024 оны 6 сарын 14-ны өдрийн 47 тоот ТУЗ-ийн тогтоолоор шинэчлэн баталсан. Тус журмын хэрэгжилтийн дагуу ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод жил бүр тайлангаа олон нийтэд мэдээлэн ажиллаж байна. ХХБ ХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журам: https://www.tdbm.mn/mn/investment/durem-juram
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	2	ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэхдээ холбогдох хууль журмыг баримтлахаас гадна ТУЗ-ийн 2023 оны 12 сарын 1-ний өдрийн 64 тоот тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмыг баримтлан ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хараат бус шийдвэрийг үндэслэн ажилладаг. Тус журманд ердийн болон хараат бус гишүүнийг томилох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгасан. Банкны хүний нөөцийн газар нь ХХБ-ны залгамж халааны бодлогыг батлан ажиллаж байгаа бөгөөд тус бодлогод удирдах болон түлхүүр ажлын байрны залгамж халааг тасралтгүй бэлтгэх, ажилтны сургалт хөгжил, чадамжийг толорхойлох болон хэрэгжүүлэх процессыг тусгасан байна. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам: https://www.tdbm.mn/mn/investment/durem-juram?page=1
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд	1	ХХБбанк нь 2019 оны 4-р сард РwС олон улсын байгууллагаас компанийн засаглалын зөвлөх үйлчилгээ авч МУ-ын холбогдох хууль, тогтоомж болон олон улсын сайн туршлагад суурилсан ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох, сайжруулах ажлыг хийж гүйцэтгэж байна. 2024 оны 12 сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн 75 тоот тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх журмыг баталж ТУЗ болон түүний дэргэдэх хороодын чиг үүргээ хэрэгжүүлж байгаа байдал, Банкны үйл ажиллагаанд ТУЗ-ийн гүйцэтгэж буй үүрэг, ТУЗ болон ГУ-ын хамтын ажиллагаа, ТУЗ-ийн дарга, гишүүдийн эрх

	<i>дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</i>		үүргийн хэрэгжилт, оролцоо, санаачилга, хараат бус гишүүдийн эрх, үүргийн хэрэгжилт, гишүүдийн мэдлэг, ур чадвар, ТУЗ-ийн ажлын дотоод зохион байгуулалт, баримт бичиг, мэдээллийн хангалт, хурлын ажиллагаа, бэлтгэл, шийдвэр гаргалт, шийдвэрийн хууль зүйн нийцэл, хэрэгжилт, хороодын үйл ажиллагааны тогтмолжилт, хурал, дүгнэлтийн чанар, ТУЗ-ийн даргын ажлын гүйцэтгэлийг үнэлхээр тусгасан. ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга болон холбогдох тайлан: https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovlo
4	<i>1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</i>	1	ТУЗ нь дэргэдээ Аудит, Эрсдэлийн удирдлага, Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх гэсэн 3 хороотой бөгөөд олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байлгахыг зорьж томилдог ба хороо тус бүр ТУЗ-өөр баталсан үйл ажиллагааны журмын дагуу зохион байгуулалтыг хийдэг. ТУЗ-ийн 9 гишүүний 5 нь эмэгтэй, 4 нь эрэгтэй буюу хүйсийн хувьд тэнцвэртэй байдлыг хадгалсан бөгөөд үйл ажиллагаандаа “Худалдаа, хөгжлийн банкны Жендэрийн эрх тэгш байдлын бодлого”-ын баримтлан ажиллаж байна. Хороодуудын танилцуулга: https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovloliin-dergedeh-horood Хороодуудын үйл ажиллагааны журам: https://www.tdbm.mn/mn/investment/durem-juram?page=2
5	<i>1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	2	ТУЗ-ийн гишүүд томилогдоод 3 ба түүнээс дээш жил болсон, өмнө нь банк санхүүгийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай хүмүүс тул одоогоор чиглүүлэх сургалтыг зохион байгуулаагүй байна. Харин шинээр томилогдсон гишүүдэд танилцуулах журмын жагсаалт гаргаж, гишүүдэд танилцах боломжийг олгосон. “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-нд тусгасны дагуу гишүүд нь хөндлөнгийн зөвлөх, мэргэжилтнээс зөвлөгөө, үйлчилгээ авах, гишүүдийн боловсрол мэдлэгийг сайжруулах зорилгоор дотоод болон гадаад эх үүсвэрээс сургалт авах, хамрагдах эрхтэй төдийгүй дотоод сургалтуудад нээлттэй оролцох боломжтой. ТУЗ-ийн гишүүдэд зориулсан 2024 оны сургалтын хөтөлбөрийг баталж, банкны төсөвт холбогдох зардлыг тусгасан.
6	<i>1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4-р бүлэгт ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ХЭХ болон ТУЗ-ийн хурлыг хуралдуулах ажлыг зохион байгуулах, бичиг хэргийг хариуцан хөтлөх, ХЭХ, ТУЗ, Гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах, түүнчлэн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.


		Банкны дүрмийн 10.1 дэх хэсэгт ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-ийн хурлаас томилохоор заасан байдаг. ТУЗ-ийн дарга нь нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилох зохицуулалтыг “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д оруулсан ба ТУЗ-ийн даргад ажлаа тайлагнан ажилладаг. ТУЗ-ийн үйл ажиллггааны журам: https://www.tdbm.mn/mn/investment/durem-juram?page=2
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ		
7	<i>2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	1 Компанийн тухай хуулийн 75.4, Банкны тухай хуулийн 33.1 дэх хэсгийн шаардлагыг хангасан буюу ТУЗ нь 3 хараат бус гишүүнтэй. ТУЗ-ийн даргыг саналын эрхтэй нийт гишүүний олонхийн саналаар ТУЗ-ийн гишүүд дундаас сонгодог ба үүний дагуу 12 өөр улсын банкны салбарт 50 гаран жил ажилласан туршлагатай банкир болох Рандолф Коппа нь ХХБ-ны ТУЗ-ийг даргаар сонгон томилсон. ТУЗ-ийн дэргэдэх Хороодыг хараат бус гишүүд удирдаж байгаа төдийгүй бүрэлдэхүүний хувьд 2/3 нь хараат бус гишүүд байна. ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга: https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovlol
8	<i>2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	2 ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрмийг 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 52 тоот ТУЗ-ийн тогтоолоор баталсан ба Аудитын хорооны зорилго, хорооны бүтэц бүрэлдэхүүн, хорооны эрх, үүрэг, үйл ажиллагааг тодорхойлсон 5 бүлэгтэй. Дүрэмд заасны дагуу Аудитын хороо нь Банкны засаглал, хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ, санхүүгийн тайлагналт, дотоод хяналтын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаанд системтэйгээр дүгнэлт өгөх, банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон бусад оролцогч талуудад үнэн зөв бодит мэдээллийг хүргэх замаар байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой. Аудитын хорооны журмын 5.7-д хурлын зохион байгуулалтын асуудлыг нарийн бичгийн дарга хариуцаж, хорооны даргын саналаар хэлэлцэх асуудлаас хамаарч, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын харьяа нэгжүүдийн удирдлага зэрэг хуралд байлцах оролцогчдыг тодорхойлохоор заасан. Энэхүү хороо нь ТУЗ-ийн хараат бус төдийгүй ТУЗ-ийн дарга бус гишүүнээр даргалуулсан болно. Аудитын хорооны танилцуулга: https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovloliin-dergedeh-horood

			Аудитын хорооны дүрэм: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	1	ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (ЦУНДХ)-ны журмыг 2022 оны 11-р сарын 15-ны 80 тоот ТУЗ-ийн тогтоолоор баталсан ба хорооны дарга нь хараат бус гишүүн болно. Хорооны үндсэн чиг үүрэг нь ТУЗ-ийн гишүүнд горилогчийн анхан шатны шалгуур, хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын бодлого журамд заасан сонгох горимын үндсэн дээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулан, ХЭХ-ийн хуралд танилцуулах, ТУЗ-ийн дэргэдэх хороонд гишүүнийг нэр дэвшүүлэх, удирдлагын багийн гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг батлах, банкны цалин, урамшууллын бодлогын төсөлд санал өгөх, банкны бүтцэд санал өгөх зэрэг болно. ЦУНДХ-ны танилцуулга: https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovloliin-dergedeh-horood ЦУНДХ-ны журам: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	1	Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо нь хараат бус гишүүнээр даргалуулсан ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд эргэн хяналт хийх, гишүүдийг сонгон шалгаруулах, үнэлэх, Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын түвшний захирлуудыг нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэж тайлагнах, тэдгээрийн цалин хөлс урамшууллын хэмжээ, бодлогыг тодорхойлох, банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалыг хөгжүүлэх чиглэл өгөх зэргээр эрх үүрэгтэй хороо болно. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	2	2024 оны 2-р сарын 7-ны 9 тоот ТУЗ-ийн тогтоолоор ТУЗ-ийн дэргэд Тогтвортой хөгжлийн хороо байгуулсан ба Хорооны зорилго нь олон улсын болон Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт, зарчмуудыг банканд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг ул мөр, банканд учирч болох эрсдэлийг бууруулах, БОНЗ-ын удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилладаг болно. Тогтвортой санхүүжилт, БОНЗ-ын бодлого, эрсдэлийн чиглэлээр олон жилийн туршлага бүхий мэргэшсэн гишүүнийг ТУЗ-ийн бүрэлдэхүүнд сонгон томилсон бөгөөд цаашлаад ХХБ-ны ТУЗ-ийн дарга нь Тогтвортой хөгжлийн хорооны даргаар томилогдсон нь холбогдох асуудлаар мэдрэмжтэй шийдвэр гаргах, зөвлөмж, мэдээ мэдээллээр хангах зэрэг өргөн хүрээгээр банкны бүхий л түвшинд ойлголтыг нэвтрүүлэн чиглүүлэх, удирдах боломжийг бий болгосон.

			Тогтвортой хөгжлийн хорооны танилцуулга: https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovloliin-dergedeh-horood
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана			
12	<i>3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	2	ТУЗ-ийн 2023 оны 2-р сарын 17 -ны 9 тоот тогтоолоор “ХХБ-ны мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ыг баталснаас гадна уг журмын хэрэгжүүлэлтийг хангах үүднээс 2023 оны 11-р сарын 10-ны А-23/608 тоот Гүйцэтгэх захирлын тушаалаар “ХХБ-ны мэдээллийн ил тод байдал, тайлагналын заавар”-ыг баталсан. Мөн СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэл журам”, МХБ-ийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам” -д заасан зохицуулагч байгууллага, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд хүргэх мэдээллийг цаг хугацаанд нь мэдээллэн ажиллаж байна. ХХБ-ны мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам: https://www.tdbm.mn/mn/investment/durem-juram?page=1
13	<i>3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекс заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	2	Кодекс заасан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг өөрийн албан ёсны цахим хаягт байршуулсан ба өөрчлөлт, шинэчлэлт орсон тухай бүрт мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Дүрэм, журмуудтай танилцах: https://www.tdbm.mn/mn/investment/durem-juram?page=0
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>	2	Банкны цахим хуудас болон арилжаа эрхэлдэг байгууллага болох Монголын хөрөнгийн биржийн цахим хаягаар дамжуулан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг олон нийтэд холбогдох хугацаанд нь нээлттэй, ил тод, тодорхой байдлаар мэдээлэн ажиллаж байна. Банкны жилийн тайлан: https://www.tdbm.mn/mn/investment/uil-ajillagaanii-il-tod-baidal Банкны жилийн үйл ажиллагааны тайлан /СЗХ-ны маягтаар/: https://www.tdbm.mn/mn/investment/uil-ajillagaanii-tailan Санхүүгийн улирлын болон аудитлагдсан тайлан: https://www.tdbm.mn/mn/about-tdbm/financial-information/sanhuugiin-auditlagdsan-tailan БОНЗ-ын тайлан: Засаглалын тайлан хэсэгт https://www.tdbm.mn/mn/investment/uil-ajillagaanii-tailan Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан: Бусад тайлан хэсэгт https://www.tdbm.mn/mn/investment/uil-ajillagaanii-tailan

ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	2	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрмийн 4-р бүлэг “Аудитын хорооны үүрэг”-ийн 4.10-4.13 дахь хэсэгт Аудитын хороо нь ТУЗ-ийг төлөөлөн хөндлөнгийн аудитын байгууллагатай ТУЗ-ийг төлөөлөн хамтран ажиллах, хөндлөнгийн аудитын үйлчилгээний нөхцөлийн талаар санал авах, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, хөндлөнгийн аудитын байгууллагын бие даасан хараат бус байдлыг хянах зэрэг үүрэгтэй байхаар заасан. Аудитын хорооны дүрэм: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	2	2024 оны 4 дүгээр сарын 29-нд болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Банкны 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлсэн Эрнст энд Янг ХХК -ийн төлөөлөл оролцсон болно. Мөн 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн ТУЗ-ийн 41 тоот тогтоолоор “ХХБ-ны Аудитын хорооны дүрэм”-д өөрчлөлт оруулж, хөндлөнгийн аудиторын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох, мэдээлэл өгөх боломжоор хангасан зохицуулалтыг 4.13 дахь хэсэгт тусгасан болно.
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	2	 Дотоод аудитын үйл ажиллагаа нь ТУЗ-ийн 2021 оны 52 тоот тогтоолоор батлагдсан Дотоод аудитын бодлогыг баримтлан ажилладаг ба Гүйцэтгэх удирдлагаас хараат бус, бие даасан байдлаар зохион байгуулалтыг Аудитын хороо болон ТУЗ-д шууд ажлаа тайлагнан ажилладаг. ДАГ болон харьяа нэгжийн удирдах ажилтныг ТУЗ, аудиторуудын ТУЗ-ийн дэргэдэх ажлын албаны бие даасан шийдвэрээр томилж, цалин урамшууллын тодорхойлдог. Банкны жилийн тайлангаас гадна ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны жилийн тайланд холбогдох мэдээллийг тусгаж, олон нийтэд мэдээлж ажилладаг. Дотоод аудит, хяналтын тогтолцоо: https://www.tdbm.mn/mn/investment/sanhuu-burtgeliin-togtoltsoo-dotood-hyanalt Дотоод аудитын бодлого: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/

ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2	 Банкны эрсдэлийн удирдлагыг банкны холбогдох нэгжүүд үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хариуцан хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагаагаа Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогчид тайлагнана. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журамд Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч нь банкны эрсдэлтэй холбоотой аливаа асуудлаар ТУЗ-д шаардлагатай нөхцөл тухай бүрд хараат бусаар тайлагнах эрхтэй байхаар зохицуулагдсан байдаг. Эрсдэлийн удирдлагын мэдээлэлтэй танилцах: https://www.tdbm.mn/mn/investment/ersdeliin-udirdlaga Эрсдэлийн удирдлагын бодлого: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	2	2023 оны 8 сарын 10-ны ТУЗ-ийн 57 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнийг 2/3 нь хараат бус гишүүнтэй, хараат бус гишүүн даргатайгаар шинэчлэн баталсан. ТУЗ-өөс баталсан журмын баримтлан үйл ажиллагаагаа явуулдаг ба хороо нь тайлангаа ТУЗ-д танилцуулж ажилладаг. Банкны үйл ажиллагаанд сөрөг нөлөө үүсгэж болзошгүй эрсдэлийн аппетитаар тодорхойлогдсон гол эрсдэлүүдтэй холбоотой зохицуулах эрх бүхий байгууллагуудын журам, заавар, эрх зүйн актуудад гарсан өөрчлөлт, банкны салбарын бодлогын хэрэгжилтийн хяналт шалгалтад баримталдаг аргачлалд орсон өөрчлөлт, банкны бизнесийн стратегийн зорилтод үзүүлэлтүүдэд нийцүүлэн эрсдэлийн удирдлагыг сайжруулах талаар банкны гүйцэтгэх удирдлагад зөвлөмж өгч ажилладаг. Эрсдэлийн удирдлагын хорооны танилцуулга: https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovloliin-dergedeh-horood Эрсдэлийн хорооны жилийн тайлан: https://www.tdbm.mn/sites/default/files/

20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	2	Байгаль орчин, нийгэмд ээлтэй, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах замаар бизнесийн үйл ажиллагааг явуулж, урт хугацаанд тогтвортой хөгжих зорилтын хүрээнд Банк нь харилцагчиддаа олгох санхүүжилтээрээ дамжуулан, зээлийн эрсдэлийг үнэлэх, бууруулах үйл явцтай адил зарчмаар харилцагчдынхаа байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэх улмаар тэдгээр эрсдэлээс үүсч болох санхүүгийн хор хохирлоос харилцагчийг хамгаалах, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг. Цаашлаад Банк нь байгаль орчин, нийгэмд ээлтэй бизнесийг санхүүжүүлэх, “НОГООН” санхүүжилтийг дэмжих, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулахыг зорилтоо болгосон. Банк нь тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нийт банкны ажилтнууд тэр дундаа зээлийн ажилтнуудаа сургах, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжээч нарыг бэлтгэж мэргэшүүлж үйл ажиллагааны бүхий л шатанд тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажилладаг. Тогтвортой хөгжлийн тайлан: https://www.tdbm.mn/mn/sustainable-development/togtvortoi-hogjliin-tailan БОНЗ тайлан: Монголын хөрөнгийн биржийн тайлагналын дагуу https://www.tdbm.mn/sites/default/files/2025-05/%D0%91%D0%9E%D0%9D%D0%97%202024%20final.pdf
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	2	ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан банкны бүтэц, зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх удирдлагын харьяанд Эрсдэлийн удирдлага хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогчийн удирдлага дор Комплайнсын хэлтэс ажилладаг. Комплайнсын хэлтэс нь Монгол улсын Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд болон олон улсын аудит ба зөвлөх үйлчилгээний байгууллага PriceWaterhouseCoopers (PWC)-ээс өгсөн зөвлөмжийн дагуу үйл ажиллагаанд Комплайнсын эрсдэлийн дүгнэлтийг гарган ажиллаж, ТУЗ-д улирал бүр үйл ажиллагаагаа тайлагнан ажилладаг ба ТУЗ нь Эрсдэлийн удирдлагын хороо болон Аудитын хороогоор дамжуулан хяналтыг тавьж, чиглэл өгч ажиллаж байна. Заавар журмандаа байнгын эргэн хяналтыг хийж хууль, журмын өөрчлөлтийг тухай бүр хийж ажиллаж банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой нийт 12 хөтөлбөр, бодлого, журмыг ТУЗ-өөр батлуулсан байна. Комплайнсын үйл ажиллагааны мэдээлэл: https://www.tdbm.mn/mn/about-tdbm/compliance

ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ			
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна			
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	2	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн зардлын хэмжээг жил бүрийн ХХБ-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулан ТУЗ-өөр баталсан хэмжээгээр цалин хөлсийг олгодог бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлыг даргалах болон оролцоонд суурилсан цалин хөлсний бодлогыг хэрэгжүүлж байна. 2024 оны 4-р сарын 29-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024-2025 оны буюу дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх зардлын төсвийг 5,000,000,000.00 (таван тэрбум) төгрөгөөр баталсан.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	2	Банк нь 2021 онд “ Чадамжид суурилсан цалин хөлсний журам”-ыг баталсан ба энэхүү журмаар цалин хөлсний тогтолцоо буюу бодлогыг тодорхойлж, ажлын байрны зэрэглэл үнэлгээнд суурилсан цалингийн сүлжээ, урамшууллын нөхцөл, эдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дүрэм журам, горим аргачлалыг баталсан болно.
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	2	ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хуралд Гүйцэтгэх удирдлагын цалин, хөлс, хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болсон эсхүл дүгнэх шаардлага үүссэн тохиолдолд тайлан, гүйцэтгэлтэй танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажилладаг. ЦУНДХ-ны журам: https://www.tdbm.mn/sites/default/files/
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ			
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ			
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	2	ТУЗ-ийн 2023 оны 2-р сарын 17-ны 9 тоот тогтоолын Хавсралт 1-ээр “ХХБ-аас бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахад баримтлах бодлого”-ыг баталсан. Банк өөрийн ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгч, Банкны үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэд болон төрийн байгууллагуудтай харилцах, хамтран ажиллахад Банкнаас баримтлах бодлогыг тодорхойлох, бусад оролцогч талуудын оролцоог хүлээн зөвшөөрөх, тэдгээрийн эрх ашгийг хүндэтгэх хамтран ажиллах, Банкны соёлыг төлөвшүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахыг зорьсон болно. ХХБ-аас бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахад баримтлах бодлого: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/

26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	2	Банкнаас бусад оролцогч талуудтай хамтран ажилласан талаарх тайланг цахим хуудсанд байршуулсан ба энэхүү тайланд харилцагч, ажилтан, зээлдүүлэгч болон банк, ханган нийлүүлэгч болон банк, төрийн байгууллага болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллахдаа 2023 онд баримталсан чиглэлийн талаар тусгасан. Банк нь өөрийн үйл ажиллагаа, бүтээгдхүүн, үйлчилгээний мэдээллийг бусад оролцогч талуудад банкны албан ёсны цахим хуудас, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр холбогдох заавар журмын дагуу тухай бүрт мэдээлэн ажиллаж байна. Оролцогч талуудтай хамтран ажилласан тайлан: https://www.tdbm.mn/sites/default/files/2025-05/
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	2	Банкны зах зээлд шинээр нэвтрүүлсэн, эсхүл өөрчлөгдөн шинэчлэгдсэн бүтээгдхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг тухайн бүтээгдхүүн үйлчилгээг хариуцаж буй газар, хэлтэс нь бусад оролцогч талуудад цахим хуудас, цахим шуудан болон бусад боломжтой арга хэлбэрээр хүргүүлж ажиллахаар үүрэгжүүлсэн.
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	1	ХХБ-ны Шүгэл үлээх бодлого, ХХБ-ны Хөдөлмөрийн дотоод журам, ХХБ-ны Ёс зүйн дүрэм, ХХБ-ны соёлын стандартын дагуу санал хүсэлтийг дотоод программ, биечлэн уулзалт хийх болон бичгээр хүлээн авч шийдвэрлэдэг. Хүний нөөцийн бодлого, Сургалт, хөгжлийн үйл ажиллагааны журам, карьер менежментийн бодлогыг батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Жил бүр сургалтын төлөвлөгөө гарган, зардлыг банкны төсөвт оруулан батлуулдаг. Түүнчлэн ХХБ-ны ажилтнуудын нийгмийн асуудлын хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр ажилтнуудын орон сууцны зээл, цалингийн зээл болон харилцагч байгууллагаас хөнгөлөлт авах зэрэг боломжуудыг олгон ажиллаж байна.
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ			
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно			
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	2	2020 онд ТУЗ-өөс банкны ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага, бүх ажилтнуудад мөрдөгдөх “ХХБ-ны Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталсан. Уг дүрэмдээ шударга байдлыг дэмжин, байгууллагын үнэт зүйлс, ёс зүйн дүрэмд зөвшөөрөгдөх болон үл зөвшөөрөгдөх зан үйлийг тодорхойлсон. Хууль, журмын нийцлийн хангах зорилгоор эргэн хяналтын тогтмол хийж 2021, 2022 онуудад тус дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах үүднээс Ёс зүйн хороог байгуулсан ба уг хороо нь тус хорооны ажиллах журам, ХХБ-ны шүгэл үлээх бодлогын дагуу эсхүл бусад байдлаар ажилтан, харилцагч

			болон гуравдагч этгээдээс ирсэн мэдүүлгийг үндэслэн шалгах ажиллагааг явуулж, шийдвэрлэх үүрэгтэй. ХХБ-ны ёс зүйн дүрэм: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	2	ХХБ-ны Ёс зүйн дүрэмд банкны ажилтны зүй бус үйлдлийг мэдээлэх асуудлыг тодорхой тусгаснаас гадна банкнаас “Шүгэл үлээх бодлого”-ыг баталж, шүгэл үлээх тохиолдол буюу зөрчил, үйлдэл, эс үйлдэхүйн жагсаалт, шүгэл үлээгчийн эрх, үүрэг, түүний хамгаалалт, мэдээллийн нууцлал, шалгах ажиллагаа, зөрчил шийдвэрлэх процесс, буруутгагдаж буй этгээдийн эрх, үүрэг, бодлогын хэрэгжилт тайлагналын талаар тусгасан байна. Хүний нөөцийн газрын зүгээс удирдах ажилтнуудад Ёс зүйн чиглэлээр улирал бүр анхааруулга, зөвлөмжийг уулзалт бүр дээр мэдээлэл өгч ажилладаг төдийгүй ажилтнуудаас жил бүр бататгах, үнэлэх тестийн шалгалтад Ёс зүйн дүрмийн мэдлэгийг баталгаажуулах асуултыг оруулан мэдлэгийг бататгаж ажилладаг.
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	2	ТУЗ-ийн тогтоолоор баталсан Ёс зүйн дүрэм болон Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан Авлигын эсрэг бодлогод авлига, хээл хахууль өгөх, авах , албан тушаалаа урвуулан ашигласан бол ёс зүйн зөрчил үйлдсэнд тооцохоор зааж, ажилтнуудын баримтлах зарчмыг дэлгэрэнгүй оруулж өгсөн. 2020 онд шинэчлэн баталсан “ХХБ-аас улс төрийн нам, төрийн бусад байгууллагатай харилцах журам”-аар Банк болон банкны ажилтан улс төрийн үйл ажиллагаанд оролцох, төрийн байгууллагатай харилцахтай холбогдсон харилцааг зохицуулсан ба үүний дотор Банк нь улс төрийн аливаа бүлэг, нам эвсэл болон Улсын их хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль, орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид хандив өгөхгүй, улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх зарчмыг баримтлахаар заасан. Харин ажилтан аливаа улс төрийн үйл ажиллагаанд оролцохдоо банкныг төлөөлөхгүй.
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ			
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана			
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	2	Банкны цахим албан ёсны хуудсанд хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан Компаний тухай хууль, Банкны тухай хууль болон зохицуулагч байгууллагуудын журам, зааврын дагуу олон нийтэд хүргэхээр үүрэг хүлээсэн мэдээллийг тухай бүр нь цахим хуудас болон бусад хэрэгслээр дамжуулан хүргэж байгаа ба цахим хуудасны хөрөнгө оруулагчдад гэсэн хэсгээс банкны бизнес, ажил үйлчилгээний талаархи шинэ соргог мэдээлэл, банкны бүтэц, зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой материал,

			ТУЗ-ийн хараат бус гишүүний тайлан, санхүүгийн тайлан, БОНЗ-ын буюу Тогтвортой хөгжлийн тайлан зэргийг харах боломжтой. Хөрөнгө оруулагч нарт зориулсан мэдээлэл: https://www.tdbm.mn/mn/investment/huvitsaa-ezemshigchid Монголын хөрөнгийн бирж мэдээлэл: https://mse.mn/mn/company/567 Санхүүгийн тайлан мэдээлэл: https://www.tdbm.mn/mn/about-tdbm/financial-information/sanhuugiin-auditlagdsan-tailan
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	2	ТУЗ-ийн 2023 оны 2-р сарын 17-ны өдрийн 9 тоот тогтоолоор “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөрөөр хөрөнгө оруулагчдын оролцоог эрх тэгш хангах, тэдгээртэй харилцах, мэдээллийг цахим сувгаар солилцохтой холбогдох харилцааг зохицуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	2	ХХБ-ны хувьцаа эзэмшигчид “Компанийн тухай хууль”, Банкны тухай хууль, “ХХБ ХК-ийн дүрэм”-д заасан бүрэн эрхийг эдэлж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхтэй оролцож, хэлэлцэж буй асуудлуудад олгогдсон эрхийнхээ дагуу саналаа өгөх замаар банкны удирдлагын үйл ажиллагаанд оролцдог. Хууль, журмын дагуу 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, ХЭ-ийн хуралд зориулсан тухайлсан цахим хуудсыг ажиллуулж зайнаас оролцох, саналаа өгөх, гарсан шийдвэртэй танилцах боломжоор ханган ажиллаж байна. Хувьцаа эзэмшигчийн хурлын цахим хуудас: https://investor.tdbm.mn/
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	2	Тус банкны хувьцаа эзэмшигчид нь “Компанийн тухай хууль”, “ХХБ-ны дүрэм”-д заасан Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг эдэлж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхтэй оролцож, хөндөгдөж буй асуудлуудад олгогдсон эрхийнхээ дагуу саналаа өгөх замаар банкны удирдлагын үйл ажиллагаанд оролцсоор ирсэн. Банкны дүрмийн 7-р буюу “Хувьцаа эзэмшигчдийн хурал” бүлэгт ХЭ-ийн оролцооны талаар тодорхой тусгасан. Дүрмийн 7.2.12 дахь заалтад нэмж хувьцаа гаргах тохиолдолд одоогийн хувьцаа эзэмшигчдийн эрхийн талаархи зохицуулалтыг тусгасан. ХХБ-ны дүрэм: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/ ХХБ-ны ХЭ-ийн хурлын зар хүргэх журам: https://www.tdbm.mn/sites/default/files/2024-09/

36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	2 2023 оны 2-р сард ТУЗ-ийн хурлаар “ХХБ-ны сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”, 2023 оны 3-р сард Гүйцэтгэх захирлын тушаалаар “Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлэлцэл хийх заавар”-ыг баталсан. Банкны албан ёсны болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хаягаар дамжуулан Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан маягтын дагуу хагас жил тутамд үйл ажиллагааны тайланд, мөн тухай бүр мэдээллэх заалтын дагуу олон нийтэд мэдээллэн ажиллаж байна. Сонирхлын зөрчилтэй хэлцэл: https://www.tdbm.mn/mn/khorongo-oruulagchdad
----	--	--



БАЯРЛАЛАА



Хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот 14120,
Сүхбаатар дүүрэг 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа,
хөгжлийн банкны төв байр



Утас:

1900-1977



И-мэйл:

boardoffice@tdbm.mn